

ӨГҮҮЛЭЛ

Энэтхэг-Номхон далайн стратегийн хүрээнд Америк-Оросын харилцаанд гарч болзошгүй өөрчлөлтийг шинжлэх нь

Цогтсайханы Буянцогтоо*

Захирал, Евразийн стратеги судлалын хүрээлэн, Улаанбаатар, Монгол Улс
buyantsogtoo@gmail.com

Одхүүгийн Үржин

Профессор, доктор Sc.D,

Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Улаанбаатар, Монгол Улс
o.urjin@gmail.com

Хураангуй: Хятадыг “хайрцаглах” зорилготой Энэтхэг-Номхон далайн стратеги нь Д.Трампын үед 2018 оноос албан ёсоор зарлагдсан бөгөөд Ж.Байдены засаглалын үед улам идэвхжин хэрэгжиж байна. Энэхүү судалгаагаар мөнхүү стратегийн хүрээнд Америк-Оросын харилцаанд орж болзошгүй өөрчлөлтийн талаар олон улсын харилцааны реализмын онол, геополитик, стратеги судлалын онолд тулгуурлан шинжилгээ хийлээ. Энэтхэг-Номхон далайн стратегийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд АНУ-ын хувьд Оростой холбоотны харилцаа үүсгэх нь гарцаагүй сонголт байх ба сүүлийн үед хоёр улсын хамтын ажиллагаанд зарим нааштай шинж тэмдэг илэрч байна гэж дүгнэлээ. Дэлхийн дэг журамд өөрчлөлт оруулахуйц томоохон цараатай энэ үйл явцад зөв дүн шинжилгээ хийж, зохих хувилбаруудыг тооцоолж байх нь Монгол улсын төрийн стратегийн чиг баримжааг зөв гаргахад зохистой нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: Энэтхэг-Номхон далайн стратеги, АНУ ба Хятадын харилцаа, АНУ ба Оросын харилцаа, Орос ба Хятадын харилцаа, “Хайрцаглах”, Дөрвөл

* Холбоо барих зохиогч



Удиртгал

Геополитикийн шинжлэх ухаанд дэлхий дахинаа улс хоорондын өрсөлдөөн дайсагнал мөнхөд орших бөгөөд тэрхүү мөнхийн дайсагнал дундаас хүч чадлаар түрэмгийлэн гарч ирж чадсан нь жанжлагч гүрэн болж дэлхийн дэг журмыг тогтооход голлох үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг. Сонирхолтой нь, түүхийн явцад дэлхий дээр цор ганц, үнэмлэхүй жанжлагч улс урт удаан хугацаанд оршиж байсан тохиолдол Чингисийн Их Монгол гүрнээс хойших дэлхийн түүхнээ бараг байдаггүй. Их Монголын цаг үеэс хойших хугацаанд дэлхийг цор ганц улс үнэмлэхүй хэлбэрээр жанжилж байсан тохиолдол богинохон хугацаанд зурвасхан үзэгдээд өнгөрч байсан цөөн тохиолдол бий. Түүхээс үзэхэд, гол төлөв дэлхийн бүс нутгуудыг хуваан захирсан хэд хэдэн жанжлагч гүрэн бий болж, тэдгээрийн хооронд хүчний тэнцвэр үүссэнээр харьцангуй урт хугацаанд энх тайван байдал тогтож ирсэн байдаг. Харин, дэлхийн хоёрдугаар дайнаас хойших хугацаанд хүйтэн дайны хоёр туйлт дэглэм үүссэн нь урьдын түүхнээ байгаагүй ховор үзэгдэл болсон юм.¹

Зөвлөлт Холбоот Улс 1991 онд хүйтэн дайнд ялагдсанаар АНУ дэлхий дахиныг дангаар жанжлах болов. Гэтэл, бусад улс гүрнүүд ил далд хэлбэрээр АНУ-ын жанжлалтай өрсөлдөх болж, бас жанжлагч гүрний өөрийнх нь алдаатай бодлогын

уршгаар хүч нөлөө нь суларсаар, улмаар 2008 онд дэлхийн санхүүгийн хямралтай нүүр тулав. Энэхүү нь сүүлийн 100 жилд болоогүй онц том хэмжээний хямрал бөгөөд АНУ-ын эдийн засгийн хүчин чадал яалт ч үгүй сулран доройтсоны нотолгоо болсон юм.

Америкийн дангаар жанжлалын тухайд тус улсын глобалист хүчний стратегич хэмээгдэн олонд алдаршсан З.Безжинский “Их шатрын хөлөг”² номондоо АНУ нь урьдын түүхэнд байгаагүй, дангаар жанжлагч онцгой хүчирхэг гүрэн байх болно гэдгийг олон талаас нь тайлбарласан байдаг. Тэрээр АНУ нь Их Монгол улс төдийгүй, Их Британи тэргүүтэй бусад жанжлагч гүрнүүдийн жишээг хол давсан жанжлагч дэглэмийг тогтоож чадна гэж үзэж байв. Чингис хааны байгуулсан Их Монгол гүрэн тухайн цаг үед мэдэгдэж байсан дэлхийн хуурай газрыг бараг бүхэлд нь хамарсан даяарчлалыг жинхэнэ утгаар бүтээж чадсан юм. Европ, Азийг холбосон мэдээлэл, худалдааны сүлжээг байгуулж, бүрэн хянаж асан Их Монголын энх тайван (Pax Mongolica) даруй 100 гаруй жилээр тоологдоно. Гэтэл, АНУ-ын дангаар жанжлал тун богинохон хугацаанд үргэлжлээд сулран доройтож эхлэв.

Дэлхийг жанжлагч гүрэн АНУ-ын хүч чадал сулрахтай зэрэгцэн БНХАУ дороос хүч түрэн гарч ирж,

1 Ito Kan. 2012. Өөрөө өөрийгөө устгах Америк гүрэн (自滅するアメリカ帝国, япон хэл дээр), Tokyo: Bungei Shunju.

2 Brzezinski, Zbigniew. 1997. The grand chessboard: American primacy and its geostrategic imperatives. New York, NY: BasicBooks.

эдийн засгаар төдийгүй цэрэг зэвсгийн хүч чадлаараа дэлхийд хоёрдугаар байранд орох болов. Тэр хэрээрээ Хятад улс жанжлагч улстай илтээр өрсөлдөх бодлогыг хэрэгжүүлсээр ирлээ. Ялангуяа, 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш Хятад улс илтэд “хамраа сөхөж”, ихээхэн түрэмгий бодлого явуулах болсон юм. Энэ байдал 2013 онд ноён Си Жиньпин төрийн тэргүүнд гарснаас хойш улам эрчээ авч байна.³

Обамагийн засаг захиргааны үед АНУ-БНХАУ хоорондын харилцаан дахь сөргөлдөөн гүнзгийрч, 2015 онд Америкийн зүгээс Хятадын эсрэг хатуухан хариу бодлого явуулахаар эргэлт буцалтгүй шийдсэн байдаг. Үүнд Хятадын зүгээс Өмнөд хятадын тэнгист хүч түрэн газар нутаг, хил хязгаараа тэлэх түрэмгий бодлого явуулж, Азийн дэд бүтцийн хөгжлийн банк байгуулах замаар АНУ-ын дэглэмийг хэрэгжүүлэгч Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын санхүүгийн бүтэцтэй өрсөлдөж эхэлсэн нь Обамагийн засаг захиргааны “тэвчээрийн хязгаарыг давсан”⁴ хэрэг болжээ.

Д.Трамп 2017 оны 1 сард АНУ-ын Ерөнхийлөгч болсноор Хятадын эсрэг хариу бодлого хэрэгжүүлэх өмнөх Засгийн газрын шийдвэрийг улам эрчимжүүлж, шинэ шатанд гаргасан юм. Трампын засаг захиргаа худалдааны дайныг эрчимжүүлэх замаар Хятадын талд дарамт үзүүлж, улмаар өндөр технологийн салбарт

томоохон хоригуудыг тавив. Ингэснээр хоёр улсын харилцаа богино хугацаанд огцом муудаж, Хятадыг дэлхийн бизнесийн нийлүүлэлтийн сүлжээнээс салгах үйл ажиллагааг өрнөдийн орнууд маш хурдтай хэрэгжүүлэх боллоо. Ингэснээр Хятадын эдийн засгийн эрчимтэй өсөлт богино хугацаанд унаж, ажилгүйдэл ихсэх, компаниуд олноор дампуурах зэрэг үзэгдэл газар авч байна.

Д.Трампын засаг захиргааны үеэс Энэтхэг-Номхон далайн стратеги гэх албан ёсны нэршил олон улсын харилцаанд түгээмэл болж, АНУ энэ стратегийг манлайлан, Япон, Австрали, Энэтхэг гэсэн 3 улсыг эгнээндээ нэгтгэсэнээр Энэтхэг-Номхон далайн стратегийг хэрэгжүүлэгч Дөрвөл гэж нэр томъёо гарч ирэв. АНУ-ын энэхүү бодлого нь жил ирэх тутам хүчирхэгжиж, Евразийн эх газрыг дамнуулан, мөн далайгаар өрнө, дорныг холбох асар том амбициа албан ёсоор зарлан хэрэгжүүлж буй Хятадын хүчийг сөрж “хайрцаглах” буюу ганцаардуудах зорилго агуулж байгаа нь илт юм. *Зураг 1*-д АНУ ба Хятадын геополитикийн сөргөлдөөнийг газрын зураг дээр үзүүлэв.

Эдүгээ 2020 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ялж, шинээр Ерөнхийлөгч болсон Ж.Байдены засаг захиргаа өмнөх Ерөнхийлөгчийн үеийн гадаад бодлогыг хэвээр үргэлжлүүлэх нь тодорхой болоод байна.⁵ АНУ тэргүүтэй холбоотон улсуудаас Хятадыг “хайрцаглах” зорилготой

3 Луттвак, Э., Хятадын стратеги 4.0, Улаанбаатар хот 2019. (Ц.Буянцогтоогийн орчуулга)

4 Луттвак, Э., Хятадын стратеги 4.0, Улаанбаатар хот 2019. (Ц.Буянцогтоогийн орчуулга)

5 White House Documents. Interim National Security Strategic Guidance. <https://www.whitehouse.gov/>

Энэтхэг-Номхон далайн стратегийг хэрэгжүүлэх явцад Америк-Оросын харилцаанд ямар өөрчлөлт орох вэ гэдэг асуултад хариу эрэх зорилгоор энэхүү судалгааг хийлээ. Энэ асуудалд геополитик, олон улсын харилцааны реализмын онол хийгээд стратегийн онолын арга хэрэгслүүдийг ашиглан шинжилгээ хийв.

Цөөн тооны реалист онолын талыг баримтлагч эрдэмтэд, тухайлбал, Чикаго их сургуулийн профессор Ж.Миершаймер, стратегийн онолч Э.Луттвак нар жанжлалын төлөө өрсөлдөж эхэлсэн Хятадыг дарах зорилгоо биелүүлэхийн тулд АНУ нь Оростой нэгдэж холбоотон болохоос өөр аргагүй гэх онолын үндэслэлийг дэвшүүлдэг. Олон улсын харилцааны шинжлэх ухааны хүрээнд авч үзэхэд эдгээр эрдэмтэд нь цөөнхөд тооцогдох бөгөөд ер нь Дэлхийн хоёрдугаар дайнаас хойших үед реализмын онолд

суурилсан судалгаа, мөн сонгодог геополитикийн салбар шинжлэх ухааны судалгаа тун ховорхон байж ирснийг тэмдэглэх нь зүйтэй. Ер нь геополитик гэдэг бол том гүрний хооронд явагддаг “тоглоом”. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш барууны ертөнцөд тогтсон либерал дэг журамд, мөн Зөвлөлтийн хүрээлэлд ч гэсэн геополитикийн шинжлэх ухааны судалгаа “хориотой” байж ирсэн юм. Тиймээс, нэр дурдсан хоёр эрдэмтэн бол тэрхүү “хориотой” гэмээр уур амьсгал дунд геополитикийн судалгаа хийсээр ирсэн, ялангуяа 1991 оноос хойших цаг үед академик ертөнцөд идэвхтэй ажиллаж буй цөөхөн тооны эрдэмтдийн төлөөлөл юм.

Дээрх эрдэмтдийн дэвшүүлж буй “Америк Оростой холбоотон болно” гэдэг үндэслэл нь олон улсын харилцаа судлалын ертөнцөд ихээхэн анхаарал татсан, цоо шинэ зүйл юм. Сүүлийн

wp-content/uploads/2021/03/NSC-1v2.pdf



Зураг 1. Хятадын хүчирхэгжилтийг “хайрцаглах” зорилго бүхий Энэтхэг-Номхон далайн стратеги

жилүүдэд урьд өмнө байгаагүйгээр харилцаа нь муудсаар байгаа энэ хоёр их гүрнийг гэв гэнэт холбоотон болно гэх нь олон улсын харилцааны либерал онолыг баримтлагч олон судлаачийн хувьд санаанд багтамгүй зүйл байж болно. Гэвч энэ нь реализмын онол, стратегийн логикийн үүднээс авч үзвэл хэрэгжих өндөр магадлалтай үндэслэл юм. Энэ жижиг судалгаагаар тэрхүү онолын үндэслэлд суурилан Америк-

Оросын харилцаанд гарч буй сүүлийн үеийн өөрчлөлт, цаашдын өрнөлийг шинжилж үзлээ. Судлаачийн зүгээс энэ ажлаараа онолын судалгаанд том хувь нэмэр оруулах зорилго өвөрлөөгүй, харин манай улсын аюулгүй байдалд шууд нөлөө үзүүлэх чухал сэдвийг хөндөн төдийлөн түгээмэл бус онолд суурилан шинжилгээ хийх өчүүхэн оролдлого хийлээ.

АНУ-ын тэргүүлж буй Энэтхэг-Номхон далайн стратегийн тухай

Д.Трампын засаг захиргаанаас 2018 онд гаргасан “АНУ-аас Энэтхэг-Номхон далайн бүс нутагт баримтлах стратегийн хамрах хүрээ” баримт бичиг нууцын зэрэглэлээс гарч ил болсон нь АНУ-ын зүгээс Хятадын эсрэг явуулах бодлогодоо ямар зарчим баримталж буйг илчлэн таниулсан, нэн чухал ач холбогдолтой үйл явдал болов. Д.Трампыг “урьдчилан таахын аргагүй, холбоотнуудаа чухалчлахын ач холбогдлыг ойлгохгүй байгаагаас холбоотон улсуудтай харилцаагаа муутгаж, тодорхой гадаад бодлогын жанжин шугамгүй явж байна” гэх зэргээр шүүмжлэгсдэд энэ баримт бичиг тэдний шүүмжлэл үндэслэл муутай байжээ гэдгийг нотолж өгөв. Д.Трампын засаг захиргаа энэ стратегийн хүрээнд “Энэтхэг, Япон, Австрали улстай аюулгүй байдлын дөрвөлсөн холбоог байгуулж, АНУ-тай нийлсэн үндсэн зангилааг үүсгэх” зорилгоо амжилттай хэрэгжүүлсэн нь илэрхий дэвшил байжээ гэж зарим мэргэжилтэн дүгнэж байна.⁶

АНУ-ын 2018 оны Энэтхэг-Номхон далайн стратегийн ерөнхий чиглэлд АНУ-ын үндэсний аюулгүй байдлын стратегийн хүрээний дотор тус бүс нутагт Америкийн стратегийн давуу талыг бэхжүүлж, Хятадын зүгээс эдийн засгийн ардчилсан дэг журмыг эвдэж, шинэ журам тогтоохоос сэргийлэх, энэ зорилгын төлөө бүс нутгийн хөгжил цэцэглэл, хамтын ажиллагааг шинээр үүсгэн хөгжүүлэхийг аюулгүй байдлын хүрээний үндсэн зорилт болгож дэвшүүлжээ. Тиймээс, энэ нь АНУ-ын байр суурьтай өрсөлдөх зорилго агуулж буй Хятад улсыг “хайрцаглах” зорилго агуулсан стратеги мөн юм. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд холбоотон улсуудтай тогтоосон харилцаагаа бэхжүүлэн хөгжүүлнэ гэж тодорхой заасан байна.⁷

2018 оны энэхүү стратегийн чухал баримт бичиг нь АНУ-ын үндэсний аюулгүй байдлын стратегийн хүрээг хамраад зогсоогүй, 2016 оны Токиогийн “Нээлттэй, чөлөөт Энэтхэг-Номхон

6 Medcalf, Rory. Declassification of secret document reveals US strategy in the Indo-Pacific. <https://www.aspistrategist.org.au/declassification-of-secret-document-reveals-real-us-strategy-in-the-indo-pacific/>

7 Medcalf, Rory. Declassification of secret document reveals US strategy in the Indo-Pacific. <https://www.aspistrategist.org.au/declassification-of-secret-document-reveals-real-us-strategy-in-the-indo-pacific/>

далай” бодлого⁸, Канберрагийн 2017 оны санаачилга⁹, түүний дотор Төрнбуллын засгийн газрын гадаад бодлогын цагаан номын үзэл санаа, Хятадын хөндлөнгийн оролцоо, тагнуулын ажиллагааны эсрэг чиглэсэн үйл ажиллагааг хамруулснаараа онцлог юм. Уул баримт бичгийг нууцын зэрэглэлээс гаргаж буйгаа нийтэд зарлах үеэр АНУ-ын ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй байдлын зөвлөх О’Брайн хэлсэн үгэндээ “Энэтхэг-Номхон далайн бодлогыг тойрон АНУ, Австрали, Энэтхэг, Япон, АСЕАН, мөн Европын гол гол холбоотон улсууд, дээрээс нь Өмнөд Солонгос, Шинэ Зеланд, Тайвань зэрэг улсууд нэгдэж энэхүү хүчирхэг нэгдлийг бий болгож байна”¹⁰ хэмээн онцолжээ. Энэтхэг-Номхон далайн дөрвөл дээр Герман, Франц улс сүүлийн үед идэвхтэй нэгдэж байна. Тэднээс хамаагүй түрүүн Их Британи ихээхэн идэвхтэй ажилласаар ирлээ. Тиймээс, өрнийн улсууд Хятадын эсрэг нэгдмэл байр суурьтай болж байна. Тухайлбал, сүүлийн Австрали улсын цэрэг, батлан хамгаалах стратегид эргэлтийн шинжтэй томоохон өөрчлөлтүүд орж байна.¹¹

Ж.Байдены засаг захиргаанаас энэ оны 3 дугаар сарын 3-ны өдөр “Үндэсний аюулгүй байдлын стратегийн түр хугацааны удирдамж”¹² хэмээх баримт бичгийг нийтэд зарласан бөгөөд энэ нь шинэ засаг захиргааны

яамд, агентлаг тус бүр өөр өөрийн салбарын стратеги, мөрийн хөтөлбөрийг боловсруулж гаргахдаа баримтлах ерөнхий удирдамж болох юм. Уг баримт бичигт үндэсний аюулгүй байдлын сорилтуудыг тодорхойлохдоо Хятадыг хамгийн том аюул мөн гэсэн нь үндэсний аюулгүй байдлаа хамгаалах тал дээр өмнөх засаг захиргааны бодлогыг хэвээр үргэлжлүүлнэ гэж дүгнэж болохоор байна. Энэ нь, мэдээж, Хятадын эсрэг чиглэсэн Энэтхэг-Номхон далайн стратегийг хэвээр үргэлжлүүлнэ гэсэн үг болж байна.

Уул баримт бичигт Хятадыг АНУ-д аюул занал учруулж буй “дайсагнагч, захиргаадалтын дэглэмтэй гүрэн” гэж онцлон тодорхойлсон бөгөөд Оросыг мөн зэрэгцүүлэн нэр дурджээ.¹² Баримт бичигт асуудлыг үндэсний хэмжээнд эрэмбэлэхдээ 1-д, Америкийн ард түмнийг хамгаалах, 2-т, эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг хангах, 3-т, америкчуудын амьдралын гол төв хэсэгт орших ардчилсан үнэт зүйлсийг хэрэгжүүлж, хамгаалах явдал гэжээ. Эхний хоёр нь Ерөнхийлөгч Трампын 2017 оны Үндэсний аюулгүй байдлын стратегийнхтай адил байна. Д.Трампын гурав дахь тулгуур “энх тайвныг тогтоож чадах хүчийг хуримтлуулж бий болгох” гэсэн зарчим байсан бол Ж.Байден ардчиллыг хамгаалах тухайд онцолж үзжээ.

8 <https://www.mofa.go.jp/files/000430632.pdf>

9 Australian Government, 2017 Foreign Policy White Paper. Opportunity, Security, Strength (Canberra, November 2017), <https://www.dfat.gov.au/sites/default/files/2017-foreign-policy-white-paper.pdf>

10 Trump White House Documents Archives. O’Brien Speech. <https://trumpwhitehouse.archives.gov/wp-content/uploads/2021/01/OBrien-Expanded-Statement.pdf>

11 Ц.Буянцогтоо, “Австралийн батлан хамгаалах стратегийн өөрчлөлт”, 212-216, SIRPA Forum 2020, Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль, Монгол улсын их сургууль, 2021.

12 White House Documents. Interim National Security Strategic Guidance. <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2021/03/NSC-1v2.pdf>

Энэтхэг-Номхон далайн стратегийн хүрээнд Америк-Оросын харилцаанд үүсч болох өөрчлөлтийг шинжлэх нь

Юун түрүүн, энэхүү судалгааны өгүүллийн үндсэн асуултад хариу эрэхдээ мөнхүү сэдвээр хийгдсэн онолын түвшний судалгаануудтай танилцлаа. Энэ зорилгоор олон улсын харилцааны шинжлэх ухааны реалист онолын эрдэмтэн Жон Миершаймер¹³, цэрэг стратегийн онолын дэлхийн шилдэг эрдэмтдийн нэг Эдвард Луттвак¹⁴ нарын онолын судалгааны ажлыг сонгон авлаа. Тэд өөрсдийн боловсруулсан хоорондоо ялгаатай онолыг хэрэглэн энэ асуудалд шинжилгээ хийсэн хэрнээ эцсийн дүндээ адил төстэй дүгнэлтийг дэвшүүлж байгаа юм.

Геополитик судлалын нэртэй эрдэмтэн, реалист онолч Ж.Миершаймер дэлхий дахинаа шинээр хүчирхэгжин гарч ирж буй Хятад гүрэн дэлхийн жанжлалын төлөө өрсөлдөх нь гарцаагүй болох ёстой үзэгдэл гэж үздэг. Тэрээр Хятад улс энх тайван замаар хүчирхэгжин гарч ирнэ гэх нь реализмын онолын үүднээс, ялангуяа түүний өөрийн боловсруулсан “давшингүй шинжит реализм”-ын онолын (offensive realism) хувьд ямар ч боломжгүй үзэгдэл гэж нотолдог. Түүний онолоор бол “хүчирхэгжин гарч ирж буй Хятад гүрэн жанжлагч гүрэн Америктай мөргөлдөх нь гарцаагүй”¹⁵ үзэгдэл юм.

Дэлхийн жанжлалын байр суурийг булаалдахуйц байр сууринд оччихоод тэрхүү тэмцлийг нэгэнт эхлүүлчихсэн

улсын хувьд эргэж буцан аядуу бодлого явуулах замаар өөрт ирэх цохилтыг зогсоож байсан түүх байдаггүй ажээ. Жанжлагч улс өөрийн байр суурийг хамгаалахын тулд өөртэй нь өрсөлдөх хэмжээнд тулж ирсэн өрсөлдөгч улсыг бараг л юу ч хийгээгүй зүгээр байж байхад нь бусад их гүрнүүдийг өөртөө татан холбоотноо болгож, эвсэл байгуулах замаар хүчээ зузаатгаж, мөнхүү өрсөлдөгч улсыг дарж авдаг гэж Ж.Миершаймер доктор тайлбарлаж байна. Тухайлбал, түүхнээ хамгийн ойрын жишээ болох империалист Герман, Их Япон улс, Зөвлөлт Холбоот Улсыг АНУ дарж авсан жишээг энэ онолоор тайлбарлаж болно. Тэдгээр гурван улсыг гурвууланг нь дэлхийн жанжлагч АНУ нь бусад холбоотнуудтайгаа хүчээ нийлүүлж байгаад “хайрцаглах” бодлого явуулж, мөн шаардлагатай үед зориудаар дайн өдөөх гэх мэт замаар дарж авсан түүхтэй.

Реализмын онолын энэхүү түгээмэл механизмын тухай тайлбарыг *Зураг 2-т* үзүүлэв. Жанжлагч гүрэн өрсөлдөгч гүрнийг гуравдугаар зэрэглэлийн том гүрэнтэй нийлж эвсэл байгуулах замаар дарж авах энэ механизм өнөөгийн АНУ-ын хувьд ч давтагдах бөгөөд АНУ нь ОХУ-тай хамтарч таарна гэж Ж.Миершаймер профессор үзэж байна. Хэдийгээр, сүүлийн жилүүдэд Америк-Оросын харилцаа хүйтэн дайнаас хойших хугацаанд

13 Mearsheimer, John J. 2001. The tragedy of Great Power politics. New York: Norton.

14 Луттвак, Э. 2019. Хятадын стратеги 4.0. Улаанбаатар. (Ц.Буянцогтоогийн орчуулга)

15 Mearsheimer, John J. 2001. The tragedy of Great Power politics. New York: Norton.



Зураг 2. Жанжлагч гүрэн өөртэйгөө өрсөлдөгч улсыг 3-р зэрэглэлийн их гүрнүүдтэй нийлж холбоотны эвсэл байгуулах замаар дарх бодлого явуулдаг.

хамгийн доод түвшинд хүртлээ муудлаа гэж тооцогдож байгаа ч, энэ хоёр гүрэн Дэлхийн хоёрдугаар дайнд хамтрагч байсныг санахад хангалттай гэж тэрээр тайлбарлаж байна.

Стратеги судлалын нэрт эрдэмтэн Э.Луттвак нь реалист онолоос арай ялгаатай хэлбэрээр, стратегийн онолын хүрээнд өөрийн боловсруулсан өвөрмөц онолын ухагдахуунуудыг хэрэглэн өнөөгийн жанжлалын төлөөх сөргөлдөөнийг тайлбарлаж байна. Түүний боловсруулсан онолд *стратегийн логик, стратегийн логикийн парадокс, их гүрний тухай онол, стратегийн соёл, сэтгэл хөдлөлөөс үүдэх алдаа*¹⁶ гэх зэрэг суурь ухагдахуунууд багтана. Тэрээр эдгээр онолын хэрэгслүүдээ ашиглан Хятадын хүчирхэгжин гарч ирж буй үзэгдлийг тайлбарлажээ.¹⁷

Түүнийхээр Хятадын төрийн удирдагчид “*стратегийн логик*”-ийг мэдэхгүйн улмаас, сэтгэл хөдлөлдөө хэт автсан нь томоохон алдаа гаргах нөхцөл бүрджээ. Өнөөгийн дэлхий дээр АНУ тэргүүтэй далайн гүрнүүд

Хятадыг “хайрцаглах” бодлогыг эргэлт буцалтгүйгээр хэрэгжүүлж эхэлсэн нь угтаа бол хятадын удирдагчдын бүдүүлэг алдаанаас үүджээ. Эдүгээ Хятад улс эдийн засгийн хүчээр АНУ-ын дараагаар хоёрт эрэмбэлэгдэх болсон ч, дэлхийд жанжлах, түүнээс түрүүн бүс нутагтаа ноёрхох хэмжээнд хүрэх нь цаг хугацааны хувьд огт болоогүй бөгөөд үүний учир шалтгааныг Хятадын төрийн стратегичид ойлгосонгүй. Жанжлагч улс эдийн засгийн хүчээр сулравч, цэргийн хүчин чадлаа хэвээр хадгалж, холбоотон улсуудтайгаа хамтын ажиллагаагаа зузаатгах, бусад их гүрнүүдийг өөртөө татах гэхчлэнгээр жанжлах байр сууриа даруй 50, 60 жилээр хадгалах чадвартай байдгийг тэд тооцоолж чадсангүй.¹⁸

Хятад улс 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаар АНУ-ын эдийн засаг суларч эхэлснийг мэдэнгүүтээ өөрсдийгөө дэлхийн жанжлагч улс болох хэмжээнд хүрчихжээ хэмээн андуурч ихээхэн түрэмгий бодлого явуулж эхэлсэн юм.¹⁹ Хятадын энэ

16 Луттвак, Э. Хятадын стратеги 4.0, 159-185, Улаанбаатар 2019. (Ц.Буянцогтоогийн орчуулга)

17 Luttwak, Edward. 2012. The Rise of China vs. The Logic of Strategy, Massachusetts: Belknap Press.

18 Луттвак, Э. Хятадын стратеги 4.0, 159-185, Улаанбаатар 2019. (Ц.Буянцогтоогийн орчуулга)

19 Luttwak, Edward. 2012. The Rise of China vs. The Logic of Strategy, Massachusetts: Belknap Press.

бодлого стратегийн томоохон алдаа болсон тухайд Э.Луттвак *стратегийн логикийн парадокс* гэдэг ухагдахуунаар тайлбарладаг. Ялахын тулд ямарваа нэг стратеги бодож гарган хэрэгжүүлж эхлэхэд цаад тал нь мөн адил хариу цохилт өгөх стратегийг хэрэгжүүлэх бөгөөд стратегийн мэдлэг хомс удирдагчид тэрхүү хариу цохилтын үр нөлөөг огтхон ч тооцоолж мэдэхгүйн улмаас “үхлийн гамшиг” дагуулсан алдаа гаргаж, төр улсаа сүйрүүлж байсан жишээ хүн төрөлхтний түүхэнд цөөнгүй байдаг ажээ. Өнөөгийн Хятад улсын төрийн стратегийг Э.Луттвак ийм төрлийн алдаа гэж үзэж байна.

Энэтхэг-Номхон далайн стратеги дээр дөрвөн том далайн гүрэн нэгдэж, Хятадыг “хайрцаглах” ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж эхэлсэн нь чухамдаа стратегийн логик үйлчилж буйн тод томруун жишээ мөн юм. Аливаа стратегийг хэрэгжүүлэхдээ эсрэг талыг хий дэмий өдөөж, түүний улмаас хариу цохилтод өртөж, улмаар өөрийн байр суурийг сулруулах нөхцөл үүсгэж орхивол тэр нь стратегийн алдаа болсон гэсэн үг. Доктор Э.Луттвак Энэтхэг-Номхон далайн стратеги нь АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулиар Д.Трампа ялагдаж, шинэ ерөнхийлөгч гарч ирлээ ч, огт өөрчлөгдөхгүй, улам эрчимтэй хэрэгжинэ гэдэг дүгнэлтийг хэдэн жилийн өмнөөс хийсээр ирлээ.

Хятадын коммунист нам өөрийн улсаа далайн гүрэн болгохын тулд Энэтхэг-Номхон далайн бүсэд өөрийн нөлөөллийг тогтоохоор тэнгисийн цэргийн хүчин чадлаа асар ихээр

нэмэгдүүлж байгаа нь, үнэн хэрэгтээ тэр нь ямар ч үр дүнгүй хөрөнгө оруулалт болж байна. Тэнгисийн цэргийн хүчээ нэмэгдүүлэх төдийгөөр аливаа улс далайн хүчин чадал гэх ойлголтыг бий болгож чаддаггүй байна. Далайн хүчин чадал (Maritime Power) гэх ухагдахуун нь далай тэнгист хамтран ажиллах холбоотон улсын тооноос шууд хамаардаг ойлголт ажээ. Гэтэл, өнөөдрийг хүртэл Хятадын коммунист нам өөрийн хүчинд хэт эрдсэн түрэмгий бодлого явуулсныхаа гороор бүс нутагтаа нэг ч холбоотонтой болж амжаагүй байна. Харин ч, эсрэгээрээ, ойр хавийн хөрш улсууд нь Хятадын түрэмгий бодлогоос болгоомжилж, АНУ-ын манлайлсан Энэтхэг-Номхон далайн стратегийн эвсэлд нэгдэж байна. Тэрээр Америк-Хятадын сөргөлдөөн цаашид урт хугацаанд үргэлжлэх магадлалтай гэж үзэж байна. Энэ сөргөлдөөн цаашид улам даамжирч шинэ төрлийн хүйтэн дайн болохоос сэргийлэх цорын ганц арга зам бол Хятад улс 2000-аад оны эхэн хүртэл хэрэгжүүлж асан аядуу зөөлөн бодлого руугаа буцаж очих явдал гэж тэр дүгнэж байна.¹⁴

Хятад улс юуны учир тийнхүү стратегийн хувьд бүдүүлэг гэмээр алдааг гаргах болов гэх асуултад Э.Луттвак “их гүрэн” гэх онолын ухагдахуунаар тайлбарлаж байна. Тэрээр Хятад улсыг “дотогшоо чиглэсэн төртэй” их гүрэн гэж дүгнэж байна.²⁰ Их гүрэн хүчирхэгжиж томорсныхоо хэрээр гадаад талаас ирэх аюулаас сэрэмжлэх шаардлагагүй болдог нь яв явсаар тийм харалган

20 Луттвак, Э. 2019. Хятадын стратеги 4.0. Улаанбаатар. (Ц.Буянцогтоогийн орчуулга)

болж, бодлогын бүдүүлэг алдаа гаргах хэмжээнд хүргэдэг талтай ажээ. Хятадын коммунист нам дотоодын томоохон асуудлууддаа түүртсэнээсээ болоод мэдээллийг хурдтай авч боловсруулах чадвараа алджээ гэж дүгнэж байна. Энэ байдал тухайн улсыг мөхөл сүйрэл рүү ч хөтөлж мэднэ.

Энэтхэг-Номхон далайн стратегийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд АНУ нь Оростой хамтарч ажиллах ёстой гэдэг дээр доктор Э.Луттвак, профессор Ж.Миершаймер нар адилхан байр суурь баримталдаг. Энэхүү стратеги бүрэлдэж бий болох явцад АНУ тэргүүтэй далайн гүрнүүд нь Оростой баг бөх хэлхээ холбоо хэдийнээ тогтоож эхэлсэн

гэж Э.Луттвак үзэж байна. Энэ нь Америк ба Оросын цэрэг, стратегийн салбарынхан харилцан бие биений сэтгэлгээний логикийг сайн мэддэг, тэр хэрээр гүнзгий ойлголцож чаддаг, аливаа эрсдлийг урьдчилан харж зайлуулсаар ирсэн он удаан жилийн хамтын ажиллагаа, сөргөлдөөний түүхийг хамт туулж ирсэнтэй холбоотой болов уу. Тиймээс, Э.Луттвакийн хэлж буйгаар Энэтхэг-Номхон далайн стратегийн хүрээнд Америк, Орос хоёр улс ойртон нягтрах үйл ажиллагаа аль хэдийнээ эхэлсэн гэж үзвэл үүний шалтгаан нь хятадын төрийн стратегичдын алдаатай бодлогоос үүдэлтэй²¹ гэж үзэж болох юм.

Америк-Оросын харилцааны сүүлийн үеийн байдал

*Трампын засаг захиргааны үеийн
Америк-Оросын харилцаа:*

АНУ-ын 2016 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар Оросыг, бас түүний удирдагч Путиныг шууд магтан сайшаадаг Дональд Трамп хэмээх БНН-ын нэр дэвшигч ялалт байгуулж Ерөнхийлөгч болов. Орост төдийгүй дэлхийн улс орнуудад 2014 оны Украины хямралаас хойш муудаад байсан хоёр их гүрний харилцаа сайжирч магадгүй гэх хүлээлт их байсан ч гэлээ, тэр нь бодит байдал дээр хэрэгжсэнгүй. Харин ч эсрэгээрээ, харилцааг улам муутгахуйц үйл явдал Америкийн дотоод улс төрд ар араасаа тасралтгүй үргэлжилж байв.

Шинэ ерөнхийлөгчийг ажлаа авангуут “Америкийн сонгуульд

оросууд хөндлөнгөөс оролцсон байж магадгүй, Трампын сонгуулийн баг оросуудтай хуйвалдсан байж болзошгүй” гэх сэжиг улстөрийн тавцнаа гарч ирж, энэ сэжгийг шалгах тусгай прокурорын баг томилогдов. 2017 оны 8 дугаар сард Америкийн холбооны улсын конгрессоор АНУ-ын Ерөнхийлөгч нь конгрессийн зөвшөөрөлгүйгээр Оросын эсрэг тавьсан эдийн засгийн хоригийг цуцлах, зөөлрүүлэхтэй холбоотой шийдвэр гаргахыг үл зөвшөөрөх агуулга бүхий Оросын эсрэг хоригийг хүчтэй болгох хуулийг батлан гаргасан цаг мөчөөс эхлэн хоёр гүрний хоорондын харилцаа сөргөлдөөний горим руу шилжин оров. 2017 оны сүүл, 2018 оны эхээр Америкийн засаг

21 Луттвак, Э. 2019. Хятадын стратеги 4.0, (21-35 дахь тал). Улаанбаатар. (Ц.Буянцогтоогийн орчуулга)

захиргаа “Үндэсний аюулгүй байдлын стратеги”, “Улсыг батлан хамгаалах стратеги” зэрэг дээд эрэмбийн баримт бичгүүдээ шинэчлэн зарлав.

Тэдгээр баримт бичгийн дотор Хятадын араас Орос улсыг нэр зааж “дэлхийн дэг журмыг өөрчлөхийг санаархагч хүчин” гэх ангилалд оруулж тодорхойлов. Энэ талаар зарим судлаачид Орос бол Америкийн хувьд аюулгүй байдлын тийм ч бодитой том аюул болж чадахгүй, учир нь эдийн засгийн хүчин чадлаар Өмнөд Солонгосоос ч илүү гарахааргүй ОХУ тийм өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах боломжгүй бөгөөд Оросыг тийнхүү тодорхойлж буй нь “үгээр тоглох” түвшний үйлдэл төдий юм гэж үзэх нь бий.

2018 оны 10 дугаар сард Д.Трампы хоёр улсын дагаж мөрдөж ирсэн дунд зайн цөмийн зэвсгийг хорогдуулах гэрээнээс гарч буйгаа зарлаж, улмаар жилийн дараа уг гэрээнээс албан ёсоор АНУ гарав. Стратегийн цөмийн зэвсгийг хорогдуулах Шинэ СТАРТ гэрээ ч бас 2021 оноос дуусгавар болоод байна.

Д.Трампын засаг захиргаа ардчилал, хүний эрх гэх мэт асуудалд анхаарал хандуулахгүй байсан нь Оросын талд ашигтай туссан юм. Обамагийн үеийнх шиг Украин, Беларусь зэрэг ОХУ-ын эргэн тойрны хуучин соц орнуудад өнгөт хувьсгал мэтийн үйл ажиллагаа явуулахгүй байв. Мөн АНУ-ын дотоодын ардчиллын хямрал бүх түвшиндээ гүнзгийрч, тэр хэрээр Америкийн ардчиллын нэр хүнд унасан нь дэлхий

даяар нөлөөлсөөр ирсэн ардчиллын зөөлөн хүч гэгчийнх нь нөлөө буурсан нь бас Орос төдийгүй бусад улсад ашигтай туссан байх магадлалтай.

Нөгөө талаас, Трампын Америк-Хятадын харилцаа богино хугацаанд хурдтай муудсан нь Украины хямралын дараагаар ойртон нягтарч эхлээд байсан Орос-Хятадын харилцааг улам гүнзгийрэх шалтгаан болов. 2018 оны 9 дүгээр сард Хятадын ардын чөлөөлөх арми Оросын зэвсэгт хүчний стратегийн томоохон сургуулилтын нэг болох “Восток 2018” арга хэмжээнд анх удаагаа оролцов. Улмаар 2019 оны 9 дүгээр сард болсон “Центр 2019”, 2020 оны 9 дүгээр сарын “Кавказ 2020” стратегийн сургуулилтад ч мөн дараалан оролцоод байна.

Улмаар 2019 оны 7 дугаар сард Орос, Хятадын стратегийн бөмбөгдөгч онгоц түүхэнд анх удаагаа Япон тэнгисийн дээгүүр хамтарсан эргүүлийн нислэг гүйцэтгэв. 2019 оны 9 дүгээр сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Оросын тал Хятадын пуужингаас урьдчилан хамгаалах систем байгуулах ажилд дэмжлэг үзүүлж буй гэдгээ олон улсын хурлын тавцнаас зарлав.²² Улмаар В.Путин Ерөнхийлөгч Орос-Хятадын харилцаа “холбоотны харилцаа” болон хөгжиж байна гэж хэлэх болсон юм. Гэвч, 2019 оны 11 дүгээр сард Хятадтай цэргийн холбоотон болох төлөвлөгөө байхгүй гэдгийг тов тодорхой илэрхийлж байв. Тэгтэл, дараа жил нь буюу 2020 оны 10 дугаар сард Орос, Хятадын цэргийн холбоотон болох тухай асуудал нь “онолын хувьд тиймэрхүү дүр зургийг

22 Valдай Discussion Club session. October 3, 2019. <https://valdaiclub.com/about/media/china-russia-missile-defense-cooperation-needed/>

төсөөлж үзэх бүрэн боломжтой” гэж В.Путин мэдэгдэв.²³ 2020 оны 11 дүгээр сард Оросын стратегийн бөмбөгдөгч онгоц Хятадтай хамтран Япон тэнгис, Зүүн хятадын тэнгист эргүүлийн нислэг үйлдэв.

Америкийн хувьд Хятадыг “хайрцаглах” үйл ажиллагаа явуулахад томоохон саад учруулах боломжтой улс бол Орос мөн гэдэгтэй маргахын аргагүй. Хэрвээ Орос-Хятадын цэргийн эвсэл үүсвэл Америкийн бодлогод ноцтой саад болж чадна. Нөгөө талаас, дангаар бие даасан бодлого явуулахыг чухалчилдаг Орос улсын хувьд Хятадтай холбоотон болох сэдэл тун бага. Тиймээс, В.Путины хэлж буй дээрх үгс нь Америкийн зүгээс Оросыг хэт дарамталж өдөөсөн ажиллагаа явуулахгүй байхыг сануулсан нэг төрлийн дохио байж болно.

Ж.Байдены үеийн Америк-Оросын харилцааг шинжлэх нь:

Байдены засаг захиргааны Оросын эсрэг чиглэсэн бодлого “ширүүхэн” эхлэх шинжтэй байсан боловч гэнэт “чиглэлээ өөрчлөн” зарим нэг нааштай гэмээр өөрчлөлтүүд гарч, улмаар хоёр гүрний төрийн тэргүүнүүд уулзсан нь харилцааг зөөлрүүлж мэдэхээр байна. Ж.Байдены Оросын талаар хатуу үзэл баримтлалтай гэдгээрээ алдартай. Тухайлбал, 2020 оны 10 дугаар сарын 26-нд CBS телевизийн ярилцлагад “Ямар улс АНУ-ын хувьд хамгаас аюултай вэ?” гэсэн асуултад “Манай улсын аюулгүй байдал, холбоотны харилцааг сулруулах гэдэг талаас авч

үзвэл хамгийн том аюул бол Орос. Дараа нь хамгийн том өрсөлдөгч улс бол Хятад” гэж хариулж байв. Энэ оны 3 дугаар сард ABC телевизийн ярилцлага дээр Путиныг алуурчин гэж үздэг гээд хэлчихсэн нь дэлхий даяар шуугиан тарив.

Оны эхнээс Оросын тэрс үзэлтэн тэмцэгч А.Навальный-тай холбоотой элдэв шуугиан эрчээ авч, Украинтай холбоотой зөрчлүүд анхаарал татаж эхэлсэн нь Ж.Байдены засаг захиргаа Оросын эсрэг хатуу бодлого явуулж, хоёр улсын харилцаа улам төвөгтэй байдалд орж болзошгүй гэмээр уур амьсгал бүрдэж байв. Ер нь Ж.Байдены Оросын талаарх үзэл баримтлал бол нэлээн хатуу. Тэр бол Орост хатуу, Хятадад талтай маягийн үзэл баримтлалтай улстөрч. Ж.Байдены *Foreign Affairs* сэтгүүлийн 2018 оны 1, 2 сарын дугаарт Майкль Карпентерийн хамтаар хэвлүүлсэн “Кремлийн эсрэг сөрж зогсох арга зам: дайсны халдлагаас ардчиллыг хамгаалах нь” гэх гарчигтай нийтлэлийн агуулгаас үзэхэд энэ нь нотлогдоно.

Уул нийтлэлд Путины Орос нь цэрэг, улстөр, эдийн засаг, мэдээлэл гэх зэрэг бүх салбарт бүх л төрлийн арга хэрэгслээр дэлхий даяар барууны ардчиллын суурийг эвдэхээр элдэв халдлагыг өдөөсөөр байна, Кремль өөрийн системийг аварч үлдэхийн тулд түүний хамгийн том дайсан болох барууны ардчиллыг өөрийн улсын хил давуулан төрөл бүрийн довтолгооныг хийсээр байна гэсэн байв. Кремль барууны ардчилалд 1) Америкийн удирдлагын дор Орост

23 AP News. October 23, 2020. Putting: Russia-China Military Alliance can't be ruled out. <https://apnews.com/article/beijing-moscow-foreign-policy-russia-vladimir-putin-1d4b112d2fe8cb66192c5225f4d614c4>

төрийн эргэлт хийх, 2) Оросын хөрш зэргэлдээ улсуудад түүний нөлөөг нь багасгах, 3) Хөрш улсуудыг ардчилснаар алсдаа Орост төрийн эргэлт хийх зэрэг санаархлыг агуулж буй хэмээн 3 том аюулыг тодорхойлж байна гэж дүгнэсэн байлаа. Цаашлаад Америкийн ардчиллыг сулруулахын тулд мэдээллийн манипуляци, хакерын халдлага зэрэг арга хэрэгслийг идэвхтэй авч хэрэглэсээр байна, эрчим хүчний зах зээлийг удирдах нь бусад улсад дарамт шахалт үзүүлэх хэрэгслийн нэг мөн гэсэн байв.

Нөгөө талаас, тэрээр Америк, Орос хоёр гүрэн стратегийн тогтвортой байдлыг хангах үүргийг харилцан хүлээж буй, стратегийн цөмийн зэвсгийг хөгжүүлэх, байршуулахыг хязгаарлах төдийгүй, талуудын хувьд стратегийн аюул гэж тооцогдох асуудлын талаар алдаатай дүгнэлт харилцан гаргахгүй байхын тулд Америкийн тал Оростой мэдээлэл солилцож байх байнгын сувагтай байх нь чухал гэдгийг онцлон тэмдэглэсэн байв. Энэ нь Ж.Байдены Оросын талаарх үзэл баримтлалыг илтгэх агуулга бүхий нийтлэл мөн боловч, нөгөө талаас энэ нь Трампын эсрэг чиглэсэн тэдний намын улстөрийн үйл ажиллагааны нэг хэсэг болж, 2016 оны Америкийн ерөнхийлөгчийн сонгуульд Оросын тал хөндлөнгөөс оролцсоныг буруушаах үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн үйлдэл байж болох талтай.

Тийм ч учраас, Ж.Байдены засаг захиргаа Орос ба Хятадын талаар ямар бодлого явуулах вэ гэдэг асуулт олон улсын харилцааны судлаачдын

анхаарал татсан сэдэв болж байсан бөгөөд түүнийг Хятадад талтай, Орост халтай бодлого явуулна гэж үзэх судлаачид цөөнгүй байсан юм. Гэвч, олон улсын харилцааны реалист онолыг баримтлагч судлаачид Трампын үеийн Америкийн гадаад бодлогод өөрчлөлт орохгүй, Хятадын эсрэг хатуу бодлогоо үргэлжлүүлнэ гэж үзэж байв. Энэ үнэн болохыг Америкийн засаг захиргаанаас энэ оны 3 дугаар сард зарласан “Үндэсний аюулгүй байдлын стратегийн түр хугацааны удирдамж” баримт бичгийн агуулга нотолж байна.

АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Антони Блинкен 2021 оны 5 дугаар сарын 17-нд Орос Германыг шууд холбосон байгалийн хий дамжуулах “*Nord Stream 2*” хоолойн төсөлд оролцож буй компаниудад хориг тавихгүй гэж зарлав. Энэ нь 6 дугаар сарын 16-нд Женевт болсон В.Путин, Ж.Байден нарын уулзалтыг угтаж зориудаар хийсэн гэмээр үйлдэл болсон юм. Хоёр улсын ерөнхийлөгчийн Женевийн уулзалт амжилттай болж өндөрлөөд байна. Энэ уулзалтаас тэгтлээ анхаарал татсан сайн мэдээ гарч ирээгүй ч гэлээ, дэлхийн хоёр том гүрний харилцаа дулаарахын эхлэл яалт ч үгүй тавигдлаа гэж хэлж болохоор байна. Хоёр талын элчин сайдууд хэвийн ажлаа үргэлжлүүлэхээр болж, стратегийн зэвсэглэлийг хорогдуулах тухай яриа хэлэлцээг эхлүүлэх гэх мэт хамтын ажиллагаа цаашид идэвхтэй өрнөх үүдийг нээсэн уулзалт боллоо гэж үзэж болохоор байна.

Америк-Оросын харилцааны цаашдын өрнөлийг шинжлэх нь

Женевт болсон Орос-Америкийн дээд хэмжээний уулзалт дээр Ж.Байдены зүгээс Оросын талд хүний эрх, ардчиллын талаар нэлээн хатуухан шаардлага тавьсан гэдгээ хэвлэлийн хурлаар мэдэгдэв. Хүний эрхийн дипломат ажиллагаагаа Америкийн тал цаашид үргэлжлүүлэх нь тодорхой байгаа ч, энэ нь төдийлөн амжилт олохгүй болов уу.

Реалист онолын үүднээс авч үзэхэд дэлхийн жанжлах байр суурийг булаалдан гарч ирж буй Хятадыг “хайрцаглах” зорилгодоо хүрэхийн тулд АНУ нь Оростой найрамдаж, улмаар цаашлаад холбоотны харилцаа үүсгэж хөгжүүлэх магадлал өндөр. Энэ тухайд дээр нэр дурдсан Ж.Миершаймер, Э.Луттвак нарын зэрэг эрдэмтэд олон жилийн өмнөөс тийм үндэслэл дэвшүүлсээр ирсэн бөгөөд сүүлийн үед АНУ-ын засаг захиргаанд ойр судалгааны байгууллага, тинк танкуудын зүгээс Орос-Хятадын харилцаа цагаас цагт улам ойртон нягтарсаар байгаад задлан шинжилгээ хийж, Оросыг Хятадаас салган холдуулах талаар тодорхой санал дэвшүүлж, хэлэлцүүлэг өрнүүлж эхэлсэн байна.

Тухайлбал, 2021 оны 1 дүгээр сарын 14-нд Америкийн тинк танк *Center for a New American Security (CNAS)* -аас “*Navigating the Deepening Russia-China Partnership*” буюу “Улам бүр гүнзгийрсээр байгаа Орос-Хятадын түншлэлийг залуурдах нь”²⁴ гэсэн нэртэй тайланг гаргасан байна. Уг

тайланд Орос-Хятад нь 1) батлан хамгаалах, 2) ардчилал, хүний эрх, 3) технологи, кибер, 4) эдийн засаг гэсэн 4 салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлсээр байгаа бөгөөд ялангуяа 1) ба 2)-ыг анхаарахгүй орхих аваас дэлхийн жанжлалын төлөө сөргөлдөж буй Америк-Хятадын тэмцэлд томоохон нөлөө үзүүлэх магадлалтай хэмээн нөхцөл байдлыг үнэлсэн байна.

Америкийн зүгээс Орос-Хятадын ойртон нягтарч буй харилцааг хэрхэн авч үзвэл зохих талаарх яриа хэлэлцүүлэг хоёр үндсэн чиглэлд хуваагддаг. Нэгд, энэ хоёр улс тэртэй тэргүй бие биедээ итгэдэггүй, хоорондоо муу учраас тэдний нөхөрлөл угаасаа хэт гүнзгийрэх явдалгүй, тиймээс санаа зовох хэрэг байхгүй гэх нэг үзэл, хоёрт, Орос-Хятадын харилцааг хөндийрүүлэх ёстой, яг л хүйтэн дайны үед Никсон ерөнхийлөгч Зөвлөлтийг “хайрцаглах” зорилгоор Хятадыг урвуулж авч байсны яг эсрэгийг одоо хийх ёстой гэсэн бас нэг үзэл зэрэгцэн оршиж ирлээ. Дээрх тайланд эхнийхийг алдаатай баримтлал гэж үзсэн бол, Никсоны стратегийн урвуу хувилбар гэх хэтэрхий энгийн хандлагаар энэ асуудлыг шийдэх боломжгүй гэж дүгнэсэн байна. Харин, ардчилсан засаглалтай холбоотон улсууд, найрамдалт улсуудтайгаа хамтрах замаар Орос-Хятадын түншлэлээс үүдэх аюул заналд бэлдэж, хариу арга хэмжээг авангаа, урт хугацаандаа Орос-Хятадын хооронд аяндаа үүсэх магадлалтай хагаралыг эвтэйхэн ашиглахаар зохих

24 Center for New American Security, 2021, “Navigating the Deepening Russia-China Partnership”
<https://www.cnas.org/publications/reports/navigating-the-deepening-russia-china-partnership>

бэлтгэлийг хангах нь зүйтэй гэжээ.

Уул тайлангаас а) Оросын тооцооллыг өөрчлөх (*Change Russia's Calculus*), б) улам бүр гүнзгийрсээр буй Орос-Хятадын хамтын ажиллагааг нүд салгалгүй ажиглаж, зохих бэлтгэлийг хангах (*Monitor and Plan for Growing Russia-China Cooperation*), в) харилцаанд үүсэх ан цавыг чадамгай ашиглах (*Exploit Fissures*) гэх мэт зөвлөгөөг санал болгожээ. (в) дотор “Орос улс нь Энэтхэг, Япон зэрэг улсыг Хятадаас хэт хамааралт байдлаас ангижрахад нэмэр болох эрсдийн хамгаалалт гэж үзэх магадлалтай” гэснээс гадна, “Оросоос Энэтхэг, Вьетнамд зэвсгээ худалдаалах ажиллагааг нь дэмжүүштэй” гэх мэт ихээхэн тодорхой алхмыг ч санал болгосон байх жишээтэй. Америкийн үндэсний аюулгүй байдлын газартай ойр

холбоо бүхий тинк танкаас ийм тайлан гарсан нь Байдены засаг захиргааны бодлогод уг тайлангийн агуулга тодорхой нөлөө үзүүлэх өндөр магадлалтай гэсэн үг юм.

Хүйтэн дайны үед АНУ-аас дэлхийн хоёр том социалист улс ЗХУ, БНХАУ хоёрыг эвдрэлцүүлэн салгах бодлогыг амжилттай хэрэгжүүлсэн түүхтэй. Энэ удаад үүнтэй адилхан ажиллагаа явуулахад төвөгтэй. Харин, Америк-Хятадын сөргөлдөөнт харилцаанд оролцож, Хятадыг дэмжихгүй байх хүсэлтийг Орост тавих магадлалтай. Үүний тулд мэдээж “наймаалцаж” таарна. Тухайлбал, Украины асуудлаар талууд тохиролцоонд хүрч болзошгүй. Мөн Оросын эдийн засагт тавьсан хоригийг аажмаар зогсоох болов уу.

Дүгнэлт

Дэлхийн дэг журамд томоохон өөрчлөлт авчрах магадлалтай жанжлалын төлөөх их гүрнүүдийн сөргөлдөөний явцыг нарийвчлан судалж, цаашдын үйл явц хэрхэн өрнөж болох талаар дүн шинжилгээ хийж, зохих мэдлэг, мэдээлэлтэй байх нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. Хятадыг “хайрцаглах” зорилгоор АНУ-ын манлайлан хэрэгжүүлж буй Энэтхэг-Номхон далайн стратегийн цаашдын үйл явцад Орос улс, ялангуяа Хятадтай тогтоож буй хамтын ажиллагаа нь томоохон саад учруулах магадлалтай гэдэг дээр Америкийн эрдэмтэн мэргэжилтнүүд, төрийн байгууллагад ойр судалгааны байгууллагууд судалгаа хийж, тодорхой саналууд дэвшүүлж

эхэлсэн байна. Манай улсын мөнхийн хоёр хөрш маань хоёулаа орооцолдсон энэхүү дэлхийн жанжлалын төлөөх сөргөлдөөнийг бид анхааралтай ажиглах шаардлагатай. Энэ сөргөлдөөнөөс үүдэн бий болж болзошгүй дэлхийн дэг журмын өөрчлөлтийг амдан судалж, зохих бэлтгэлийг хангавал зохино.

АНУ нь Энэтхэг-Номхон далайн стратегийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Орос-Хятадын хамтын ажиллагааг саармагжуулах, улмаар Оросыг өөрийн талдаа татах ажиллагааг ямар нэг байдлаар явуулж хэрэгжүүлэх магадлал өндөр байна. Энэ хүрээнд Америк улс юун түрүүн Оросыг Япон, Энэтхэг, Вьетнам гэх мэт бүс нутгийн бусад улсуудтай эдийн засаг, цэрэг, улстөрийн чиглэлээр хамтран ажиллах явдлыг

дэмжих магадлалтай. Ийм төрлийн хамтын ажиллагаанд оролцох нь манай улсад ашигтай байж болох уу гэдгийг бид судалж үзүүштэй.

Их гүрнүүдийн сөргөлдөөн, хамтын ажиллагааны явцад манай талд ямар эрсдэл, аюул занал үүсэж болох талаар бид судлах хэрэгтэй байна. Хятад улс давын өмнө бүс нутагтаа ноёрхлоо тогтоох, Америкийн нөлөөг багасгах, үгүй болгохыг зорьж буй. Энэ ажиллагаа нь юун түрүүн Хятадын өмнөд хил, Номхон далай руу чиглэж байгаа юм. Тиймээс, Хятадын зүгээс Тайвань, Сэнкаку арлууд, Зүүн хятадын тэнгис, Өмнөд хятадын тэнгис хавийн бүс нутагт ихээхэн хүч анхаарал тавьсаар байна.

Хятадын Номхон далай руу чиглэсэн үйл ажиллагааг саармагжуулах зорилгоор Америкийн зүгээс тус улсын хойд хил хавиар тогтворгүй байдлыг үүсгэх тактик барьж магадгүй юм. Иймэрхүү санааг Америкийн стратеги судлаач Ж.Григел дэвшүүлсэн буй.²⁵ Тухайлбал, манай улстай хил залгаа Шинжаан Уйгурт тогтворгүй байдал үүсгэж болзошгүй. Иймэрхүү хямралт байдалд манай улсад ямар нөлөө үзүүлж болохыг шинжилж, түүнд манайх ямар нэг байдлаар татагдан орохоос сэргийлэх нь зүйтэй.

Давшингүй шинжит реализмын онолд (offensive realism) жанжлагч улс

эдийн засаг, цэрэг армийн хүчээр өөртэй нь дүйх хэмжээнд хүчирхэгжин гарч ирж буй улсыг өөрийнх нь эсрэг шууд сөргөлдөх маягийн үйлдэл хийгээгүй байлаа ч гэсэн хүч нөлөөг нь дарж сулруулах бодлогыг авч хэрэгжүүлдэг гэж үздэг. Тэгвэл өнөөгийн Хятад улс АНУ-ын байр суурийг сулруулах, улмаар орыг нь эзэлж авах бодлогыг ил тодоор хэрэгжүүлсээр удаж байгаа учраас энэ хоёр их гүрний сөргөлдөөн ойрын ирээдүйд тасралтгүй үргэлжлэх нь илэрхий болж байна.^{26,27} Магадгүй, энэхүү жанжлалын дайн 10-20 жил ч үргэлжилж болзошгүй.

Тиймээс, Америк-Оросын харилцаа ойрын ирээдүйд аажмаар сайжирч, хэвийн болох өндөр магадлалтай бөгөөд сүүлийн саруудад хоёр улсын харилцаанд дулаарах шинж төлөв орж эхэллээ гэж судлаачийн зүгээс дүгнэж байна. Монгол Улсын хувьд үндэсний аюулгүй байдлаа хангах тал дээр онцгой анхаарч ажиллах ёстой цаг үе тулж ирж байна. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд “...дотоод болон гадаад аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр, арга зам хоорондоо тэс өөр байдаг”²⁸ гэдгийг анхаарч, тэдгээрийг тус тусад нь авч үзэж, холбогдох судалгааг нарийвчлан хийх нь төрийн бодлогыг боловсронгуй болгон сайжруулахад хувь нэмэр болох учиртай.

25 Grygiel J.Jakub, 2006. Great Powers Geopolitical Change, The Johns Hopkins University Press.

26 Ц.Буянцогтоо, Нэг бүс, Нэг зам санаачилгын геополитикийн стратеги, Олон улсын харилцаа сэтгүүл, 16-26 тал, 2017 No.: 1/36 (501), ISSN 2308-8125, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль, МУИС.

27 Ц.Буянцогтоо, Америк, Хятадын харилцаа: дэлхийн шинэ хүйтэн дайн эхлэв үү?, “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл, 46-56 тал, No.: 26 (36), 2018, ISSN 2220-9115, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн.

28 О.Үржин, “Үндэсний аюулгүй байдал” нэр томъёоны ойлголтыг цэгцлэх асуудалд, “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл, 5-14 тал, No.: 26 (36), 2018, ISSN 2220-9115, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн.

Ашигласан материал

Монгол хэлээр:

1. Ц.Буянцогтоо, “Австралийн батлан хамгаалах стратегийн өөрчлөлт”, 212-216, SIRPA Forum 2020, Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль, Монгол улсын их сургууль, 2021.
2. Ц.Буянцогтоо, *Нэг бүс, Нэг зам санаачилгын геополитикийн стратеги*, Олон улсын харилцаа сэтгүүл, 16-26, 2017 No.: 1/36 (501), ISSN 2308-8125, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль, МУИС.
3. Ц.Буянцогтоо, *Америк, Хятадын харилцаа: дэлхийн шинэ хүйтэн дайн эхлэв үү?*, “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл, No.: 26 (36), 2018, ISSN 2220-9115, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн.
4. Луттвак, Эдвард. 2019. *Хятадын стратеги 4.0*. Улаанбаатар. (Япон хэлнээс хөрвүүлсэн Ц.Буянцогтоо)
5. О.Үржин, “*Үндэсний аюулгүй байдал*” нэр томъёоны ойлголтыг цэгцлэх асуудалд, “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл, 5-14 тал, No.: 26 (36), 2018, ISSN 2220-9115, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн.

Гадаад хэлээр:

1. Australian Government. 2020. Defence Strategic Update 2020. https://www.defence.gov.au/StrategicUpdate-2020/docs/2020_Defence_Strategic_Update.pdf
2. Australian Government. 2020. *Force Structure Plan 2020*, https://www.defence.gov.au/StrategicUpdate-2020/docs/2020_Force_Structure_Plan.pdf
3. Australian Government, *2017 Foreign Policy White Paper. Opportunity, Security, Strength* (Canberra, November 2017), <https://www.dfat.gov.au/sites/default/files/2017-foreign-policy-white-paper.pdf>
4. Foster, Gregory. *Biden’s Interim National Strategy is good, if small, first step*. <https://www.defenseone.com/ideas/2021/03/bidens-interim-national-security-guidance-good-if-small-first-step/172532/>
5. Medcalf, Rory. *Declassification of secret document reveals US strategy in the Indo-Pacific*. <https://www.aspistrategist.org.au/declassification-of-secret-document-reveals-real-us-strategy-in-the-indo-pacific/>
6. Mearsheimer, John J. 2001. *The tragedy of Great Power politics*. New York: Norton.
7. Trump White House Documents Archives. *U.S. Strategic Framework for the Indo-Pacific*. <https://trumpwhitehouse.archives.gov/wp-content/uploads/2021/01/IPS-Final-Declass.pdf>

8. Trump White House Documents Archives. *O'Brien Speech*.
<https://trumpwhitehouse.archives.gov/wp-content/uploads/2021/01/O'Brien-Expanded-Statement.pdf>
9. White House Documents. *Interim National Security Strategic Guidance*.
<https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2021/03/NSC-1v2.pdf>
10. Center for a New American Security (CNAS) 2021. <https://www.cnas.org/publications/reports/navigating-the-deepening-russia-china-partnership>
11. Grygiel J.Jakub, 2006. *Great Powers Geopolitical Change*, The Johns Hopkins University Press.

Analyzing the Possible Changes in America-Russia Relations within Indo-Pacific Strategy

Buyantsogtoo Tsogtsaikhan*

*Director, Institute for Eurasian Strategic Studies, Ulaanbaatar, Mongolia
buyantsogtoo@gmail.com*

Urjin Odkhuu

*Sc. Dr, Professor, Mongolian National Defense University, Ulaanbaatar, Mongolia
o.urjin@gmail.com*

Abstract: *The Indo-Pacific Strategy to contain China has started officially in Trump era since 2018. It is now even more accelerated during the Biden administration. This research work has done an analysis on a change of US and Russia's relations within the strategy based on theory of realism, geopolitics, and strategic studies. The researcher has concluded that to make alliance with the Russian Federation to conduct the strategy successfully is an inevitable choice for the US, and now some positive signs of the cooperation between two great powers are already being observed. Investigating these major events which have a potential to change world order and predicting possible scenarios are important for Mongolia in shaping the right direction for the country's grand strategy.*

Keywords: *Indo-Pacific Strategy, U.S. and China Relations, U.S. and Russia Relations, Russia and China relations, Containment, Quad*

<i>The day of submission:</i>	2021.06.30
<i>Completion of review:</i>	2021.07.03
<i>Final decision for acceptance:</i>	2021.07.05

* Corresponding author